

**ЛЭНДМН ББСБ ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2022 оны 03 дугаар сарын 26-ны өдөр

№ 22/01

Улаанбаатар хот

“ЛэндМН ББСБ” ХК /цаашид “Компани” гэх/-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал /цаашид “ХЭЭХ” гэх/ 2022 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 12:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Нью Майнд ХХК-ийн байрны 3 давхрын хурлын өрөөнөөс цахимаар зохион байгуулагдав.

Цахим хуралд “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал, ХЭЭХ-ын дарга Б.Удвал, Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн дарга О.Болдбаатар, Компанийн Санхүү, үйл ажиллагаа хариуцсан захирал, ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал, Тооллогын комиссын дарга, Өмгөөллийн ЭмДиЭс энд Хаанлекс ХХН-ийн партнер С.Батбуян, ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Ж.Мөнхцэцэг нар оролцов.

**ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал хурлыг хөтлөн явуулав.**

**ХЭЭХ-ын дэгийн дагуу тооллогын комиссын дарга, ЭмДиЭс энд ХаанЛекс ХХН-ийн партнер С.Батбуян хурлын ирцийг танилцуулав.**

“ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчид өнөөдрийн 09:00 цагаас эхлэн <https://survey.lend.mn/> цахим хуудаст хандаж саналаа урьдчилан өгөх боломжтой байгаа.

Саналаа урьдчилан өгөх боломжтойгоос гадна ХЭЭХ-аар хэлэлцэх асуудал тус бүрийг танилцуулж, асуулт, хариулт, хэлэлцүүлэг явагдсаны дараа <https://survey.lend.mn/> цахим хуудсаар санал хураалт явагдана. Хэрэв саналаа урьдчилан өгсөн бол энэ хэсэгт дахин санал өгөх боломжгүй. ХЭЭХ-ын дэгийн дагуу санал хураалтын хугацаа дуусахад санал хураалтын цахим хуудас хаагдах тул үүнээс хойш санал өгөх боломжгүй гэдгийг Та бүхэн анхаараарай.

Санал өгөх цахим хуудаст нэвтрэх нэр, нууц үгийг ашиглаж нэвтэрснээр Таны хурлын ирц цахимаар хуралд оролцсоноор баталгаажиж, бүртгэгдэж байгаа.

Урьдчилсан байдлаар саналын хуудсаар санал өгсөн эсэх тухайд 2022 оны 03 сарын 25-ны өдрийн 18:00 цаг хүртэл үнэт цаасны компаниудаар дамжуулан саналын хуудсаар урьдчилан санал өгөх боломжтой байсан. Тухайн тогтоосон хугацаанд саналын хуудсаар ирсэн санал байхгүй.

Өнөөдрийн 12:00 цагийн байдлаарх ХЭЭХ-ын ирц цахим системд баталгаажсан байна. “ЛэндМН ББСБ” ХК-ийн ХЭЭХ-д саналын эрх бүхий хувьцааны 84.28 хувь буюу 623,059,564 ширхэг хувьцаа эзэмшиж буй 37 хувьцаа эзэмшигч оролцсоноор Компанийн тухай хууль /цаашид “КтХ” гэх/-ийн 69.1<sup>1</sup>-т зааснаар ХЭЭХ хуралдуулах ирц бүрдэж, ХЭЭХ хүчин төгөлдөр болж байгааг хувьцаа эзэмшигчид болон ХЭЭХ-ын даргад мэдээлж байна.

**ЛэндМН ББСБ ХК-ийн Гүйцэтгэх захирал, ХЭЭХ-ын дарга Б.Удвал хурлыг нээж үг хэлэв.**

---

<sup>1</sup> 69.1.Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно.

Төлөөлөн удирдах зөвлөл болон компанийн нийт хамт олны өмнөөс эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

2021 онд “ЛэндМН ББСБ” ХК маань нийгэм, эдийн засгийн тодорхойгүй нөхцөл байдал буюу Ковид-19 цар тахалтай холбоотой шинэ нөхцөл байдалд дасан зохицож, үйл ажиллагаагаа хэвийн тогтвортой үргэлжлүүлэхэд анхааран ажиллалаа. Үүнтэй холбоотойгоор шинээр хэрэгжиж буй Монгол Улсын хууль, Засгийн газрын тогтоол, шийдвэрүүд, зохицуулагч байгууллагуудаас гаргасан мэдэгдэл, журмыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллалаа. Бид хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагч мөн ажилтнуудын хувьд шаардлагатай шийдвэрүүдийг тухай бүр гарган ажиллалаа. Хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгах, хөрөнгийн үнэ цэнийг хамгаалах шийдвэрүүд, мөн харилцагч нартаа зээлийн эргэн төлөлтөнд уян хатан, боломжит нөхцөлийг санал болгох, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг SuperUp болон LendMN аппликейшнүүдээр дамжуулан нэвтрүүлэх шийдвэрүүдийг гаргалаа. Бид ажлын байрыг 100% хадгалсан төдийгүй ажилтнууддаа зайнаас ажиллах, мөн сурч хөгжих боломжийг олголоо. Үйл ажиллагаандаа дотоод шинэчлэл хийж финтек компанийн хувьд суурь болсон систем хөгжүүлэлтэд онцгойлон анхаарч системийн шинэчлэлтийг хийлээ. Ингэснээр дараа дараачийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг илүү богино хугацаанд гаргах дэд бүтэц бий болж байгаа бөгөөд үүний үр дүнд бизнесийн өсөлтийг хангах боломж бүрдэж байгаа юм.

2021 онд компани үндсэн үйл ажиллагаанаасаа 4.0 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, зорилтот түвшинд хүрсэн тул Компанийн ТУЗ-өөс 2022 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит хурлаар нэгж хувьцаанд 1.5 төгрөг буюу нийт 1.1 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчиддээ мөнгөн хэлбэрээр хуваарилахаар шийдвэрлэлээ. Нэгж хувьцааны ногдол ашгийн дүн болох 1.5 төгрөг нь Ковид 19-ын өмнөх үе буюу 2019 оны нэгж хувьцааны ногдол ашгийн дүнтэй ижил байгаа юм. Энэ нь манай үйл ажиллагаа тогтворжин, сэргэж байгааг харуулж байна.

Бид хувьцааныхаа хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгийн үнэ цэнийг хамгаалах үүднээс хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг хоёр удаа зарласан. ТУЗ-ийн 21/17 тоот тогтоолоор батлагдсан уг хөтөлбөрийн хүрээнд 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 19,088,587 (*арван есөн сая наян найман мянга таван зуун наян долоо*) ширхэг хувьцааг халаасаллаа.

2021 онд Дижитал хөрөнгө оруулалт “ЛэндБонд” уриатай ЛэндБонд-2, ЛэндБонд-3 нээлттэй бондуудыг амжилттай гаргаад байна. ЛэндБонд-2 захиалгыг 2021 оны 6 дугаар сарын 25-30-ны өдрүүдэд зарлаж нийт 505 хөрөнгө оруулагчаас 5.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг амжилттай татан төвлөрүүлсэн. ЛэндБонд-2 хүрээнд нийт 7.5 тэрбум төгрөгийн захиалга хүлээн авсан нь “ЛэндБонд” маань Дижитал хөрөнгө оруулалтын брэнд болж эрэлт өндөртэй байсныг харуулж байна.

Түүнчлэн нийт 5.6 тэрбум төгрөгийн дүнтэй ЛэндБонд-3 хөтөлбөрийг хэсэгчлэн гаргах нөхцөлтэйгөөр хэрэгжүүлж байна. ЛэндБонд Транч I-ийг LendMN аппликэйшнээр дамжуулан анхдагч зах зээлийн арилжаа эхлүүлсэн ба нийт 44 хөрөнгө оруулагчаас 2.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг амжилттай татан төвлөрүүллээ.

2021 онд Монголын хөрөнгийн бирж түүхэндээ хамгийн өндөр өсөлт үзүүлсэн жил болсон. Энэ өсөлтөнд ЛэндМН-ий хувьцаа халааслах хөтөлбөр, нээлттэй бонд гаргах хөтөлбөрүүд тодорхой нөлөө үзүүлсэн.

Цар тахлын үед хэрэглэгч нартаа зориулан зайнаас авах боломжтой хөрөнгө оруулалтын цоо шинэ бүтээгдэхүүн болох PLUS итгэлцлийн үйлчилгээг SuperUp аппликейшнээр дамжуулан амжилттай нэвтрүүллээ.

Мөн хурдтай хөгжиж буй крипто арилжаанд оролцогчдын хувьд өөр хоорондоо крипто арилжаалах хүсэлт үүсгэж, төлбөрийн асуудлаа LendMN-ээр хялбар шийдэн төгрөгөөр гүйлгээ хийх боломж бүрдлээ. Дэлхийд тэргүүлэгч crypto exchange болох Binance дээр LendMN аппликейшн маань P2P буюу хөрөнгө оруулагчид өөр хоорондоо төлбөр хийх төлбөрийн хэрэгслээр нэмэгдсэн сайхан мэдээг харилцагч Та бүхэндээ дуулгахад таатай байна.

Үүнээс харахад LendMN аппликейшн маань зөвхөн зээлийн аппликейшн төдийгүй хөрөнгө оруулалтын хялбар шийдлийг ч мөн санал болгож байгааг харж болно.

Өнгөрөгч 2021 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар 1 сая ам.доллар буюу 2.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг 5 жилийн хугацаатай, 14%-ийн хүүтэй хоёрдогч өглөгөөр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх шийдвэр гарч, Санхүүгийн зохицуулах хорооноос зохих зөвшөөрөл авсаны үндсэн дээр ЛэндМН компани маань өөрийн хөрөнгийг хоёрдогч өглөгөөр нэмэгдүүллээ.

Өмнөх хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд дурьдаж байсанчлан 2021 онд үйл ажиллагаагаа өргөжүүлэх чиглэлд дараах ажлуудыг хийгээд байна.

- ✓ Цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан цахим зээлийн гэрээг үе шаттайгаар байгуулж эхэлсэн ба одоогоор Улаанбаатар хот төдийгүй бүх аймагт гэрээ байгуулах боломжийг бүрдүүлээд байна. Ингэснээр LendMN аппликэйшнээр дамжуулан алслагдсан орон нутгийн иргэд санхүүгийн үйлчилгээ авах боломжтой боллоо.
- ✓ ЛэндМН нь үнэнч, найдвартай харилцагч нартаа зориулан байгаль орчинд ээлтэй, хагас цахилгаан моторт автомашиныг зээлээр авах боломжийг олголоо. Харилцагч LendMN аппликейшнд бүртгэлтэй, цахим зээлийн гэрээ байгуулсан, мөн кредит скоринг шаардлагыг хангаж байгаа бол энэхүү бүтээгдэхүүнийг авах боломжтой юм. Бидний зүгээс эко автомашины зээлийн бүтээгдэхүүнээ улам боловсронгуй болгохоор зорин ажиллаж байна.
- ✓ LendMN нь нээлттэй хамтын ажиллагааны зарчмын хүрээнд Бета Стар ХХК-тай хамтран худалдан авалтын зээлийн үйлчилгээ, мөн Ай Эн Нэтворк ХХК-тай хамтран SuperNet дата болон интернэт төхөөрөмжийг зээлээр авах зээлийн үйлчилгээг нэвтрүүлээд байна.
- ✓ Нийгмийн хариуцлагын хүрээнд зээлийн эргэн төлөлтөнд хүндрэл учирсан харилцагчиддаа зээлийн үндсэн төлбөрийн 10%-ийг (хамгийн багадаа) шимтгэлийн хамт төлж зээлээ хэдэн ч удаа сунгах боломжийг бүрдүүлэн ажиллалаа.
- ✓ Дэлхий даяар байгаль орчны өөрчлөлтөд анхаарал хандуулж буй энэ цаг үед ЛэндМН нь ногоон санхүүжилтийг дэмжих, Монгол Улсын хэмжээнд тулгараад буй байгаль орчны хор нөлөөг бууруулахад өөрийн хувь нэмрийг оруулах, энэхүү үйл хэрэгт Монгол Улсын банк бус санхүүгийн байгууллагуудыг манлайлан ажиллах зорилгоор Монголын тогтвортой санхүүгийн холбоо (ТоС Холбоо)-нд гишүүнээр элссэн. Энэхүү зорилгын хүрээнд компанийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээнд байгальд ээлтэй байх зарчмыг хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөж байна.
- ✓ Бизнесийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах, дэлхийд өрсөлдөх бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох, байгууллагын хамт олон хамтдаа өсөн дэвжиж, тасралтгүй хөгжих тал дээр анхааран ажиллаж байна. ЛэндМН-ийн үндсэн систем болон аппликейшнийг хөгжүүлэгч АНД группын охин компани болох АНД Сольюшн ПтивЛтд болон АНД Системс Тех ХХК-уудтай технологи нийлүүлэх болон лицензийн гэрээг үзэглэлээ. Тодруулбал уг гэрээгээр үндсэн систем нийлүүлэх, сайжруулах, хөгжүүлэх үйлчилгээ үзүүлэх нөхцөлүүдээ шинэчлэн баталсан нь зээлийн болон хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнээ нэмж, үйл ажиллагаагаа тэлэх таатай нөхцөлийг бүрдүүлж байна.

- ✓ 2022 онд “одоо аваад дараа төл” хэлбэрийн LendPay худалдан авалтын зээл, 12 сар хүртэлх хугацаатай зээл, шугаман зээлийн бүтээгдэхүүн зэрэг бүтээгдэхүүн үйлчилгээг шинээр гаргахаар төлөвлөж байна. 2022 оны 4 дүгээр сараас LendPay бүтээгдэхүүнийг нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна. LendMN-ийн зээлийн эрхтэй харилцагчид дахин кредит скор хийлгэхгүйгээр одоо байгаа зээлийн эрхээрээ ЛэндМН-тэй хамтрагч байгууллагуудаас хүссэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ урьдчилгаагүй шууд аваад, хүү шимтгэлгүй хуваан төлж, төлөлт бүртээ урамшууллын Бонус оноо авах боломжтой болно.

2022 онд Компаний маань үйл ажиллагаа улам өргөжин тэлнэ гэдэгт итгэлтэй байна.

**ЛэндМН ББСБ ХК-ийн Гүйцэтгэх захирал, ХЭЭХ-ын дарга Б.Удвал хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг танилцуулав.**

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хариуцах
1	Хурлын ирц бүртгэх	11:30-12:00	Тооллогын комисс
2	Хурлын ирцийг мэдээлэх	12:00-12:05	Тооллогын комиссын дарга
3	Хурлыг нээх, хурлын дэг танилцуулах	12:05-12:15	Хурлын дарга
4	Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулах	12:15-12:30	Гүйцэтгэх захирал
5	Компанийн ТУЗ-ийн тайлан, 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх	12:30-13:00	ТУЗ-ийн дарга
6	Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах	13:00-13:15	ТУЗ-ийн дарга
7	Компанийн ТУЗ-д гишүүнд нэр дэвшигчидийг танилцуулах	13:15-13:30	ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин, урамшууллын хорооны дарга
8	Компанийн ТУЗ-ийн 2022 оны төсвийн саналыг танилцуулах	13:30-13:45	Гүйцэтгэх захирал
9	Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон асуулт, хариулт	13:45-14:00	Хурлын дарга
10	Хэлэлцэж байгаа асуудлуудаар санал хураах	14:00-14:20	Хурлын дарга, Тооллогын комиссын дарга
11	Санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг батлуулах	14:20-14:40	Тооллогын комиссын дарга
12	Хурлаас гарах шийдвэрийн төсөлд Хувьцаа эзэмшигчдийн санал хураалтын дүнг тусган, танилцуулж, батлуулах	15:00-15:15	Хурлын дарга, Хурал зохион байгуулах комиссын дарга

## ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлан танилцуулах;
2. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах;
4. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 5 гишүүнийг улируулан сонгох;
5. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 4 гишүүнийг шинээр сонгох;
6. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны төсвийг батлах;

## ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 1: Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан танилцуулах

*Танилцуулсан нь: Б.Удвал, ЛэндМН ББСБ ЖК-ийн Гүйцэтгэх захирал*

### БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- ✓ Нийт актив: 39.3 тэрбум төгрөг;
- ✓ Нийт орлого: 12.5 тэрбум төгрөг;
- ✓ Цэвэр ашиг: 4.0 тэрбум төгрөг;
- ✓ Зээлийн багц: 32.4 тэрбум төгрөг
- ✓ Бүртгүүлсэн харилцагчийн тоо: 2020 оны байдлаар 890,481 байсан бол 2021 онд 987,372 буюу 11%-ийн өсөлттэй;
- ✓ Зээлийн харилцагчийн тоо: 2020 оны байдлаар 175,271 байсан бол 2021 онд 182,528 буюу 4%-ийн өсөлттэй;
- ✓ Олгосон зээлийн тоо: 2021 онд 867,000 удаагийн 183.4 тэрбум төгрөгийн зээл.

### ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Харилцагчийн үйлчилгээний төв нь 27 ажилтантай ба аппликэйшн ашиглалт болон бусад үйлчилгээний талаар харилцагчдад тухай бүр шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

- ✓ Хүлээн авсан нийт дуудлага: 266,807;
- ✓ Хүлээлгийн түвшин: 15 секунд;
- ✓ Үйлчилгээ амжилттай хүргэсэн: 98.85 хувь;
- ✓ Сошиал сувгаар үйлчилсэн: 61,062 /үйлчилгээний заал/.

### ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- ✓ Гэрээт харилцагчдын тоо: 182,528;
- ✓ Цэвэр зээлийн багц: 32.4 тэрбум төгрөг;
- ✓ Зээл олголт: 183.4 тэрбум төгрөгийн 867 мянган зээл;
- ✓ Зээл сунгалт: 120.9 тэрбум төгрөгийн 767 мянган зээл.

### САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- ✓ Нийт хөрөнгийн хэмжээ: 39.3 тэрбум төгрөг /цэвэр зээлийн багц 32.4 тэрбум төгрөг, мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө 4.9 тэрбум төгрөг/;

- ✓ Өр төлбөр: 19.5 тэрбум төгрөг;
- ✓ Өөрийн хөрөнгө: 19.8 тэрбум төгрөг /хуримтлагдсан ашиг 11.3 тэрбум төгрөг/
- ✓ Нийт актив:
  - 2019 онд 58.1 тэрбум төгрөг;
  - 2020 онд 40.7 тэрбум төгрөг;
  - 2021 онд 39,3 тэрбум төгрөг;
- ✓ Нийт пассив:
  - 2019 онд 40.9 тэрбум төгрөг;
  - 2020 онд 23.0 тэрбум төгрөг;
  - 2021 онд 19,5 тэрбум төгрөг;
- ✓ Нийт хөрөнгийн өгөөж:
  - 2019 онд 8.5%;
  - 2020 онд 6 .0%;
  - 2021 онд 10.2%;
- ✓ Нийт өөрийн хөрөнгийн өгөөж:
  - 2019 онд 28.5%;
  - 2020 онд 13.7%;
  - 2021 онд 17.7%;
- ✓ Орлого:
  - 2019 онд 18.0 тэрбум төгрөг;
  - 2020 онд 16.4 тэрбум төгрөг;
  - 2021 онд 12.5 тэрбум төгрөг;
- ✓ Цэвэр ашиг:
  - 2019 онд 4.9 тэрбум төгрөг;
  - 2020 онд 2.4 тэрбум төгрөг;
  - 2021 онд 4.0 тэрбум төгрөг.

## **ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 2: Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх**

***Танилцуулсан нь: О.Болдбаатар, ТУЗ-ийн дарга, АНД Глобал компанийн захирал***

КтХ болон Компанийн Дүрмийн дагуу ТУЗ-өөс групп компани (ЛэндМН болон түүний охин компани)-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийх байгууллагаар Эрнст энд Янг Монголия Аудит ХХК-ийг сонгохоор шийдвэрлэсэн. Тус компанийн хувьд ЛэндМН-ийн санхүүгийн тайланд 5 дахь жилдээ хөндлөнгийн аудит хийж байгаа ба аудитын компанийн зүгээс 2021 оны санхүүгийн тайланд аудит хийж, олон улсын стандартын дагуу гаргасан жилийн аудитлагдсан тайлантай тохирч байна гэсэн дүгнэлт гаргасан. Энэхүү тайланг 2022 оны 2 сарын 07-ны өдөр ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо болон ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг **‘хангалттай’** гэж дүгнэсэн.

Иймд өнөөдрийн ХЭЭХ-аар ТУЗ-өөс ЛэндМН ББСБ ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэсэн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, баталж өгөхийг Та бүхнээс хүсч байна.

## **ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 3: Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан танилцуулах**

***Танилцуулсан нь: О.Болдбаатар, ТУЗ-ийн дарга, АНД Глобал компанийн захирал***

Компани үйл ажиллагаагаа бэхжүүлэх, зохистой түвшинд удирдах, стратегийн зорилтдоо хүрэхэд нь Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/ ерөнхий удирдлагаар хангаж, хяналт тавихын зэрэгцээ Гүйцэтгэх удирдлагад компанийн үйл ажиллагааг үр ашигтай, үр дүнтэй удирдахад нь шаардлагатай чиглэлийг өгч ажилладаг.

Төлөөлөн удирдах зөвлөл нь эрх үүргээ бүрэн хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгын хүрээнд Компанийн дүрэм, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмаар тодорхойлсон тодорхой чиг үүрэг бүхий 1/ Эрсдэлийн удирдлагын хороо, 2/ Аудитын хороо, 3/ Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороодтой ажиллаж байна.

2021 оны 3 дугаар сард Компанийн ХЭЭХ-аар томилогдсон ердийн 6, хараат бус 3 гишүүний бүрэлдэхүүнтэй ТУЗ хууль дүрмийн дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлж ирлээ. ТУЗ-ийн хараат бус гишүүн Болдын Өлзийбаяр нь 2021 оны 9 дүгээр сарын 08-ны өдөр ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ ирүүлсэний дагуу ТУЗ тухайн гишүүний хүсэлтийг хүлээн авч, 2021 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр ТУЗ-ийн хараат бус гишүүнээс чөлөөлсөн. ТУЗ-ийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалт, ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны дүгнэлтийг үндэслэн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн ээлжит бус хурлаар Монгол Улсын иргэн, “ПрайсвотерхаусКуперс Аудит” ХХК-ийн Менежер Даваасамбуу овогтой Галхүүг ХЭЭХ хуралдах хүртэл хугацаанд ТУЗ-ийн хараат бус түр гишүүнээр томилоод байна.

ТУЗ тогтмол хуралдаж, холбогдох тогтоол шийдвэрийг гарган ажиллаж байгаа ба өнгөрсөн нэг жилийн хугацаанд 5 удаа ээлжит, 7 удаа ээлжит бусаар хуралдаж, нийт 46 тогтоол гаргажээ. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо 5 удаа, Эрсдэлийн удирдлагын хороо 5 удаа, Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо 3 удаа тус тус хуралдсан байна.

ТУЗ-өөс Компанийн үйл ажиллагааг зөв зохистой удирдахад чиглэсэн бодлогын бичиг баримтуудыг батлан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах чиг үүргийнхээ хүрээнд Компанийн “Бизнес төлөвлөгөө” болон “Мэдээллийн аюулгүй байдлын бодлого”-ыг баталсан ба “Эрсдэлийн удирдлагын бодлого”, “Зээл түүнтэй адилтгах активыг ангилах, зээлийн эрсдэлээс хамгаалах сан байгуулах, зарцуулах бодлого”-д тус тус нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэн баталсан.

**ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 4: Компанийн ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох эсэх;**

**ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 5: Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай;**

***Танилцуулсан нь: О.Болдбаатар, ТУЗ-ийн дарга, АНД Глобал компанийн захирал***

Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүн Н.Цэвэгмид, Б.Дэлгэржаргал, Ц.Одмаа нар нь ТУЗ-ийн ердийн гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ илэрхийлсэн ба ТУЗ-ийн 2022 оны 03 дугаар сарын 26-ны өдөр буюу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын өдөр бүрэн эрхийн хугацаа дуусч байгаа.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 4.2-т “Саналын эрх бүхий энгийн хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч саналаа ТУЗ-ийн Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороонд гаргах замаар нэр дэвшүүлэх эрхээ хэрэгжүүлж болно. Хувьцаа эзэмшигч өөрийн нэрийг ТУЗ-ийн гишүүнд дэвшүүлж болно.” гэж заасны дагуу компанийн хувьцааны 75.0%-ийг эзэмшиж буй АНД Системс ХХК-аас Б.Хос-Эрдэнэ, Ц.Ууганбаяр, Б.Итгэл нарыг ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшүүлэх санал ирүүлсэн.

АНД Системс ХХК-аас ирүүлсэн санал, Б.Хос-Эрдэнэ, Ц.Ууганбаяр, Б.Итгэл нарын холбогдох баримт бичигт дүн шинжилгээ хийсний үндсэн дээр нэр дэвшигчид нь Монгол Улсын КтХ-ийн 77 дугаар зүйлийн 77.1 дэхь хэсэг, Компанийн дүрмийн 11 дүгээр зүйл болон Компанийн ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэхь заалтад тус заасан шаардлагуудыг бүрэн хангасан гэж дүгнэсэн.

Түүнчлэн Компанийн ТУЗ-ийн 2021 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн ээлжит бус хурлын шийдвэрээр Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Өлзийбаярын чөлөөлөгдөх хүсэлтийг хүлээн авч бүрэн эрхийг зогсоосон. ТУЗ-ийн хараат бус гишүүнийг ХЭЭХ-аар нөхөн сонгох хүртэл хугацаанд хараат бус гишүүн Б.Өлзийбаярыг түр орлох этгээд томилох шаардлага үүссэн ба Компанийн ТУЗ-өөс ТУЗ-ийн хараат бус түр гишүүн сонгох нээлттэй шалгаруулалт явуулж, ТУЗ-ийн хараат бус гишүүнийг түр орлох этгээдээр Д.Галхүүг томилсон.

Нэр дэвшигчид нь Компанийн ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.1, 3.3-т заасан компанийн ТУЗ-ийн гишүүнд тавигдах шалгуурыг бүрэн хангасан бөгөөд ёс зүйн өндөр төлөвшилтэй, эдийн засаг болон санхүүгийн зах зээлийн боловсрол эзэмшсэн, бизнесийн салбарт мэргэшсэн хэмээн дүгнэж байна.

ТУЗ-ийн гишүүдийн танилцуулгыг хувьцаа эзэмшигчдэд дэлгэцээр танилцуулав.

## **ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 6: ТУЗ-ийн 2021 оны төсвийг батлах**

**Танилцуулсан нь: Б.Удвал, ЛэндМН ББСБ ХК-ийн Гүйцэтгэх захирал, ХЭЭХ-ын дарга**

ТУЗ-ийн 2022 оны төсвийн саналын хувьд өмнөх онтой ижил 153.1 сая төгрөг байгаа. Үүнээс 143.1 сая төгрөг цалин урамшуулалд, 10 сая төгрөг хурал зохион байгуулах болон бусад зардалд зарцуулагдахаар төсөвлөгдсөн байна.

Компанийн Дүрмийн дагуу ТУЗ 9 гишүүнтэй байх ба ТУЗ-ийн дэргэд 3 хороо ажиллана. Цалин урамшууллын хэмжээний хувьд Монголын хөрөнгийн биржид байршсан хувьцаат компаниудын жишигтэй харьцуулан гаргасан.

Иймд хувьцаа эзэмшигч Та бүхнийг ТУЗ-ийн 2022 оны төсвийг батлах санал хураалтад саналаа өгөхийг хүсч байна.

**АСУУЛТ/ ХАРИУЛТ: ЛэндМН ББСБ ХК-ийн Санхүү, үйл ажиллагаа хариуцсан газрын захирал, ХЭЭХ-ыг зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал хуралд оролцогчдоос ирүүлсэн асуултыг багцлан асууж, Компанийн Гүйцэтгэх захирал холбогдох хариултыг өгөв.**

**Асуулт 1: Ногдол ашигаа яаж авах вэ, хэзээ авах вэ?**

**Хариулт:** ЛэндМН компани маань 2021 онд 4.0 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Компанийн ТУЗ-ийн 2022 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит хурлаар 2021 оны цэвэр ашигаас нэгж хувьцаанд 1.5 төгрөгөөр тооцож нийт 1.1 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчиддээ мөнгөн хэлбэрээр хуваарилахаар шийдвэрлэсэн. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг 2022 оны 02 сарын 25-ны өдрөөр тасалбар болгон гаргасан. 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК руу ногдол ашгийг



шилжүүлж, 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хувьцаа эзэмшигчид маань өөрийн бүртгэлтэй брокерийн компаниудаар дамжуулан ногдол ашигаа авах боломжтой болно. Хувьцаа эзэмшигчдийн брокерийн компани дахь бүртгэлтэй дансанд шууд шилжиж орно.

**Асуулт 2: Танайх богино хугацааны зээлээс гадна ямар шинэ бүтээгдэхүүнүүд гаргасан бэ? Энэ талаар мэдээлэл өгнө үү?**

**Хариулт:** 2021 оны онцлох үйл явдлын танилцуулга видеонд энэ талаарх мэдээлэл орсон. 2021 онд хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнээс гадна зээлийн бүтээгдэхүүнийг шинээр оруулсан байгаа. Тухайлбал, үнэнч харилцагч нартаа зориулан эко автомашины зээлийг санал болгосон. Энэ нь байгаль орчинд ээлтэй хагас цахилгаан автомашин байхаар зээлийн автомашины төрлүүдийг тодорхой заасан байгаа. Харилцагч LendMN аппликэйшнээрээ ороод зээлийн эрхээ шалгуулаад, хэрэв зээлийн эрх үүссэн тохиолдолд Харилцагчийн үйлчилгээний төв рүү хандаж нэг өдрийн дотор өөрийн сонгосон, тавигдсан шаардлагад нийцэж байгаа цахилгаан авто машиныг шууд авах боломжтой. Дараагийн нэг бүтээгдэхүүн бол итгэлцлийн үйлчилгээг SuperUp аппликэйшнээр дамжуулан оруулсан. 2022 оны 3 сараас эхлэн LendMN аппликэйшн маань хөрөнгө оруулалт цэстэй болсон. Хөрөнгө оруулалт цэсээрээ дамжуулан PLUS итгэлцлийн үйлчилгээг авах боломжтой. Мөн өмнө дурдсан LendPay худалдан авалтын зээлийн үйлчилгээг санал болгохоор бэлтгэл ажлуудаа хангаад явж байна.

**Асуулт 3: Гэрээгээ түр цуцалсан байсан. Одоо дахин зээл авч болох уу?**

**Хариулт:** Харилцагч өөрийн хүсэлтээр гэрээгээ цуцалсан байгаа бол дансны хуулгаа дахин уншуулаад, кредит скоринг шаардлага хангаж байвал дахин Харилцагчийн үйлчилгээний төв эсвэл ЛэндМН-ий гэрээт нотариат дээр очин гэрээгээ байгуулаад зээлийн эрхийнхээ дагуу зээлийн үйлчилгээгээ аваад явах боломжтой.

**Асуулт 4: 2021 онд халаасалсан хувьцаагаа цаашид яах вэ? Стратегийн хөрөнгө оруулагчиддаа халаасны хувьцаа санал болгох уу?**

**Хариулт:** Халаасалсан хувьцааг эргээд Монголын хөрөнгийн бирж рүү гаргах эсэх талаар зохицуулагч байгууллагаас тодорхой зохицуулалт гараагүй байгаа. 2021 оны байдлаар 19,088,587 ширхэг хувьцааг халаасалсан. Цаашид яах талаар одоогоор тодорхой шийдвэр гараагүй байна. Олон нийтэд нийлүүлэхгүй, хадгалж байна.

**Асуулт 5: Хөдөө орон нутагт зээл гарах уу?**

**Хариулт:** Хөдөө орон нутагт зээл гарч байгаа. Нийт 21 аймагт болон Улаанбаатар хотод шинээр зээлийн гэрээ байгуулаад ажиллаж байна. Харилцагч дансны хуулгаа илгээгээд зээлийн эрхээ шалгуулах хэрэгтэй байгаа. Кредит скоринг шаардлага хангаад зээлийн эрх үүсвэл тухайн аймаг дахь ЛэндМН-ий гэрээт нотариат дээр очиж зээлийн гэрээгээ байгуулснаар зээл аваад явах боломжтой. Тайланд танилцуулснаар манай харилцагчдын 35 хувь орон нутагт байгаа. Тэгэхээр LendMN аппликэйшнээр дамжуулж байгаа гол давуу тал нь тухайн аймагт заавал өөрийн салбартай байх шаардлагагүй, нотариат дээр гэрээгээ байгуулсан тохиолдолд хүссэн үедээ зээлээ аваад явах боломжтой байгаа. Хамгийн гол нь харилцагч маань кредит скорингийн шаардлагыг хангасан байх ёстой.

**Асуулт 6: LendPay зээлийн эрх харагдаад байна. Яаж ашиглах вэ?**

**Хариулт:** Энэ бол манай шинээр нэвтрүүлж байгаа бүтээгдэхүүн байгаа. Одоогийн байдлаар LendMN-ий зээлийн эрхтэй харилцагчид дахиж кредит скоринг хийлгэхгүйгээр одоо байгаа эрхийнхээ хүрээнд энэ бүтээгдэхүүнийг шууд ашиглаад явах боломжтой байгаа. LendPay тэмдэглэгээтэй ЛэндМН-ий хамтран ажиллагч байгууллагууд дээр харилцагч хүссэн бараа, үйлчилгээгээ урьдчилгаа хүү, шимтгэлгүйгээр шууд авах боломжтой байгаа. Төлбөрөө 60 хоногийн хугацаанд 4 хуваагаад төлөх боломжтой. Аппликэйшнээр шууд ашиглахаас илүүтэйгээр ЛэндМН-тэй хамтран ажиллаж байгаа байгууллагууд дээр очих, тэндээсээ бараа, үйлчилгээгээ сонгох шаардлагатай юм.

**Асуулт 7: Зээл олгохоо зогсоосон байгаа юу?**

**Хариулт:** Зээл олгож байгаа. 2021 онд нийтдээ 867,000 зээлийг шинээр олгосон. Үйл ажиллагаа хэвийн явж байна. Зарим харилцагчийн тухайд LendMN дээр зээлээ удаа дараа хугацаа хэтрүүлсэн, эсвэл Монголбанкны ЗМС-д муу зээлийн түүхтэй гэх мэт шалтгаанаар кредит скорингийн шаардлагын дагуу зээлийг түтгэлзүүлсэн байгаа.

**Асуулт 8: Хувьцаа яаж нэмж авах вэ? Хувьцааны талаар мэдээлэл өгнө үү?**

**Хариулт:** ЛэндМН-ий хувьцаа Монголын хөрөнгийн бирж дээр арилжаалагддаг. Компани маань МХБ-ийн топ 20 компанийн нэг байгаа. Харилцагч, хувьцаа эзэмшигчид хувьцаа нэмж авах сонирхолтой байвал өөрийн бүртгэлтэй брокер, диллерийн компаниудад хандаж хүсэлтээ өгөх хэрэгтэй.

**Асуулт 9: Зээлийн эрх маань харагдаад байгаа ч зээл авч болохгүй байна. Яах вэ?**

**Хариулт:** Өмнө дурдсанчлан зарим харилцагчдын хувьд LendMN-ий зээлийн эргэн төлөлтийн түүх дээр удаа дараа хугацаа хэтрүүлж байсан, эсвэл ЗМС-д чанаргүй зээлийн түүхтэй бол зээл авч чадахгүй байх магадлалтай. Нөгөө талаар манай Харилцагчийн үйлчилгээний төвд хандан асуудлаа шалгуулах боломжтой.

**Асуулт 10: Хөрөнгийн биржийн сайт дээр ЛэндМН хурлаа Сувд төвийн 201 тоотод хийнэ гэсэн зар тавьж хувьцаа эзэмшигчдийг төөрөгдүүлж, хүнд суртал гаргалаа гэсэн санал комментоор орж ирж байна.**

**Хариулт:** Компанийн ТУЗ-ийн тогтоолоор Компанийн ХЭЭХ-ыг 2022.03.26-ны өдөр цахим хэлбэрээр хуралдуулахаар шийдвэрлэсэн. Энэ шийдвэрийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, компанийн сошиал хуудас болон хувьцаа эзэмшигчидэд мессежээр мэдээлсэн байгаа. Мөн МХБ-ийн сайт дээр журмын дагуу ХЭЭХ-ын зарыг мэдээлсэн.

**Асуулт 11: Бонус оноогоо ашиглаад зээлийн эрхээ нэмсээр дээд түвшиндээ хүрсэн. Дахин нэмэгдүүлэхийн тулд яах ёстой вэ? Бонус онооны талаар мэдээлэл өгнө үү.**

**Хариулт:** Бонус онооны хувьд яг одоогийн байдлаар сошиал сувгаар ч тэр, бусад хэлбэрээр харилцагчдаас хамгийн их асуудаг асуултуудын нэг байгаа. Бонус оноо маань өөрөө анх гарч ирсэн

зориулалт нь компани барьцаагүй зээл гаргаж эхэлж байсан үеэс эхлэлтэй бүтээгдэхүүн байгаа. Бонус оноо нь харилцагчийн зээлээ хугацаандаа эргэн төлөлтийг урамшуулдаг оноо байгаа. Хугацаандаа эргэн төлөлт хийх бүрт бонус оноогоо аваад явдаг. Бонус оноогоороо өөрийн зээлийн лимитийг нэмэгдүүлэх, эсвэл зээлийн шимтгэлийн дүнг бууруулах зорилготой бүтээгдэхүүн юм. Үндсэндээ бонус оноогоороо зээлийн түвшингээ нэмэгдүүлээд явах, эсвэл зээлийн хүүгээ бууруулаад яваад байж болно.

Шинээр үүсгэж байгаа боломжийн хувьд 2021 оноос эхлээд эко автомашины зээлийн эрх үүссэн харилцагчийн хувьд бонус оноогоо ашиглаад авто машины зээлийн хүүг бууруулах боломжийг олгосон. 2022 онд системийн шинэчлэлтүүд хийгдэж байгаа ба системийн шинэчлэлтийн дараагаас бонус онооны дээд түвшиндээ тулчихсан байгаа харилцагчид маань үргэлжлүүлээд бонус оноогоо ашиглаад лимитээ нэмээд явах боломж бүрдэнэ. Цаашид хамтран ажиллагч байгууллагуудтай бонус оноогоо хэрхэн ашиглаж болох тал дээр тодорхой төслүүд явж байгаа. Өнгөрсөн жил гэхэд бид Дижитал Молл ХХК-тай хамтраад VanapaMall-оос бонус оноогоороо ваучер авч, бараа үйлчилгээ, бүтээгдэхүүнийг илүү хямдралтайгаар авах боломжийг олгож байсан.

**Асуулт 12: Бондоор мөнгө татан төвлөрүүлж байгаа. Энэ мөнгийг юунд зарцуулах вэ?**

**Хариулт:** 2022.03.23-ны өдөр СЗХ-оос ЛэндБонд 3-ын Транч II-ийг эхлүүлэх зөвшөөрлөө авсан. 3/24-нд бондтой холбоотой үндсэн мэдээллийг өөрийн сошиал сувгаар дамжуулан лайваар өгсөн. Бондын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл ЛэндМН пэйж дээр хадгалаатай байгаа энэ лайвыг үзэх боломжтой байгаа. Бондын татан төвлөрүүлсэн хөрөнгийн хувьд гол зарцуулалт нь зээлийн үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх. 2022 онд дараа дараагийн зээлийн шинэ бүтээгдэхүүнээ гаргах төлөвлөгөөтэй байгаа. Тухайлбал, авто машины зээлээ үргэлжлүүлээд гаргана. Мөн илүү урт хугацаатай LendPay худалдан авалтын зээл гарна.

**Асуулт 13: Бондын хүүнд яг хэдэн төгрөг хуримтлагдах вэ?**

**Хариулт:** Бондын Транч I-ийг 14.0% хүүтэй зарласан. Транч II-ийн хүү 15% болсон. Өөрөөр хэлбэл жилийн 15%-ийн хүүтэй, 6 сар тутам өгөөжөө авах боломжтой. Брокер, диллерийн компаниуд бондоос авах орлогын татвар болох 5%-ийг суутгаад харилцагчиддаа шилжүүлдэг буюу татвараа хасаад 14.5%-ийн өгөөжтэй гэсэн үг.

**Асуулт 14: 2022 онд дахин хувьцаа халааслах хөтөлбөр хэрэгжих үү?**

**Хариулт:** Одоогоор ямар нэгэн шийдвэр гараагүй.

**Асуулт 15: Транч гэж юу вэ?**

**Хариулт:** СЗХ-оос компанийн өрийн бичиг гаргахтай холбоотой шинэ журам гарсан. Транч гэдэг нь хөтөлбөртэйгөөр буюу бонд гаргаж буй компанидаа хэрэгцээтэй үедээ бондыг хэсэгчлэн гаргах боломжийг олгож байгаа. Үүнийг ээлж буюу транч гэж нэрлэж байгаа. Хэсэгчилсэн байдлаар эх үүсвэрүүдээ татаж байгаа гэсэн үг.

**Асуулт 16: 2021 онд гаргасан бондоос худалдан авсан. Өгөөжөө яаж авах вэ?**

**Хариулт:** Бондын өгөөжөө өөрийн бүртгүүлсэн брокер, диллерийн компани дахь данс руугаа шууд авч байгаа. Компанийн хувьд өгөөжийг 6 сар тутамд “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн данс руу шилжүүлж байгаа.

**Асуулт 17: Би 2022.02.24-ний өдөр хувьцаа нэмж авсан. Энэ хувьцаандаа ногдол ашиг авах уу?**

**Хариулт:** Бүртгэлийг 2022.02.25-ны өдөр хүртэл гэж зарласан байгаа учир ногдол ашиг авна гэсэн үг.

**Асуулт 18: 2022 онд зээлийн шинэ бүтээгдэхүүн гаргах уу?**

**Хариулт:** LendPay бүтээгдэхүүн гарна. Урт хугацаатай худалдан авалтын зээлийн бүтээгдэхүүн байгаа. Мөн шугаман зээлийн бүтээгдэхүүн гаргахаар ажиллаж байна.

**Асуулт 19: Бүртгэлтэй дугаараа яаж солих вэ?**

**Хариулт:** LendMN аппликэйшний цэс рүү ороод бүртгэлээрээ нэвтэрч, шууд засах боломжтой байгаа. Бүртгэлтэй дугаар руу мэдээллүүд явдаг учир шинэ дугаараа бүртгүүлэх нь чухал байгаа.

**Асуулт 20: Хөрөнгө оруулалт цэс нэмэгдсэн байсан. Энэ талаар мэдээлэл өгнө үү.**

**Хариулт:** 2022 оны 3 сараас хөрөнгө оруулалт гэсэн цэс нэмэгдсэн. Энэ цэсний гол зорилго нь LendMN дээр хөрөнгө оруулалтын боломжуудыг олгож байгаа. Одоогийн байдлаар итгэлцлийн үйлчилгээ болон ЛэндБондыг захиалах боломжтой байгаа. ЛэндБонд-ын Транч II-ын захиалгыг мөн энэ цэсээр дамжуулан захиалж болно. Цаашид улам өргөжүүлж бусад хувьцаа худалдаж авах боломжуудыг нэмж оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

**Асуулт 21: Оруулсан хөрөнгө оруулалтаасаа ногдол ашиг авч байгаа нь сайхан байна. Гэхдээ зээлийн хугацаа хэтрэлт хэр байдаг бол? Төлөгдөхгүй зээл дээр санаа зовж байна. Энэ тал дээр байр сууриа илэрхийлнэ үү.**

**Хариулт:** Зээлийн үйл ажиллагаа явуулж байгаа компанийн хувьд зээл гаргах нь чухал байгаа хэдий ч нөгөө талаасаа чанаргүй зээлийг аль болох бага түвшинд байлгах гэдэг бол хамгийн чухал. 2021 онд нийт чанаргүй зээлийн дүн 5.17% байсан. Энэ нь салбарын дундажтай харьцуулбал харьцангуй бага байгаа. ЛэндМН-ий хувьд чанаргүй зээл, хугацаа хэтэрсэн зээлүүдтэй ажилладаг бүтэц байгаа. Аль болох хугацаанд нь төлүүлэх, нөгөө талаасаа хугацаандаа зээлээ төлсөн санхүүгийн сахилга баттай харилцагчдаа урамшуулах тал дээр байнга анхаарал хандуулж ажилладаг. Мөн эрсдэлийн сангаа байгуулаад явж байгаа.

**Асуулт 22: Бондоо эргүүлэн зарахдаа хаана хандах вэ?**

**Хариулт:** Бондод хөрөнгө оруулагч маань бэлэн мөнгөний хэрэгцээ шаардлага гарвал МХБ-ээр хэсэгчлэн зарах боломжтой. Ингэхдээ бүртгэлтэй брокерийн компанидаа хүсэлтээ өгөөд зарж болно.

**Асуулт 23: Бондын давуу тал юу ву?**

**Хариулт:** ЛэндБондын Транч II захиалга эхэлж байгаатай холбоотой бондтой холбоотой асуултууд нэлээд байх шиг байна. Бондын давуу тал нь толгой компани болох АНД Глобал компанийн 100% баталгаатай байгаа. Мөн бондын өгөөж жилийн 15.0% байгаа. Дундаж хадгаламжийн хүү 8.0% гэж тооцвол ЛэндБондын хүү харьцангуй өндөр юм. Хадгаламжийн хүүгийн орлогоос 10% орлогын албан татвар авдаг бол бондын өгөөжөөс 5.0% татвар авдаг. ЛэндБонд Транч II маань 2 жилийн хугацаатай гарч байгаа. Энэ хугацаанд хүүгийн хэмжээнд өөрчлөлт орохгүй. Бондод хөрөнгө оруулагч нар 6 сар тутамдаа өгөөжөө аваад явах боломжтой байна.

**Асуулт 24: Бондыг хугацааны хувьд сунгаж болох уу?**

**Хариулт:** Бонд 2 жилийн хугацаатай гарч байгаа. Хугацаа сунгаж болохгүй.

**Асуулт 25: Өнгөрсөн жил ногдол ашигаа аваагүй. Нөхөж авч болох уу?**

**Хариулт:** Хэрэв өмнө нь хувьцаа эзэмшигч байсан бол бүх хувьцаа эзэмшигчиддээ ногдох ногдол ашгийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар дамжуулан шилжүүлсэн байгаа. Тиймээс бүртгэлтэй брокерийн компани руугаа хандан, ногдол ашигаа авах ёстой.

**Асуулт 26: LendMN аппликэйшн дээр тооцоолох жагсаалтанд байна гэж гарч ирээд байгаа. Энэ хэзээ нээгдэх вэ?**

**Хариулт:** 2020 оны хувьд Ковид нөхцөл байдалтай уялдуулаад зээлийн үйл ажиллагааг бага зэрэг хумих бодлого барьсан. Харилцагч нарын хувьд дахин зээлийн эрхийг нь тогтоох үүднээс кредит скоринг хийх шаардлагатай болсон. Харилцагч үргэлжлүүлэн зээл авах хүсэлтэй байгаа бол дансны хуулгаа дахин илгээж зээлийн эрхээ тогтоолгох шаардлагатай. Дансны тухайд аль болох орлого хүлээж авдаг дансаа холбуулж уншуулбал зүгээр байгаа.

**Асуулт 27: Одоо гарч байгаа бондын нөхцөлийн талаар дэлгэрэнгүй танилцуулга өгч болох уу?**

**Хариулт:** Нийт 3.1 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 31,000 ширхэг бондыг олон нийтэд санал болгож байгаа. Бондын захиалга 3/28-30-ны хооронд LendMN апп болон андеррайтер компани болох “Өлзий энд Ко Капитал” ҮЦК болон синдикат “Райнос Инвестмент” ҮЦК-ууд, мөн бусад брокер компаниудаар дамжуулан захиалга өгөх боломжтой байгаа. Бондын нөхцөлийн хувьд жилийн 15.0%-ийн хүүтэй, 6 сар тутам өгөөж төлөгдөх, нийт 2 жилийн хугацаатай. Бондын нэрлэсэн үнэ 100,000 төгрөг. АНД Глобал компанийн 100% баталгаатай.

3/25-ны өдрөөс эхлэн Central Tower болон Shangri-La дээр BOOT гарган бондын дэлгэрэнгүй мэдээллийг өгч байгаа.

## **ХУРЛЫН ДЭГИЙН ДАГУУ ХЭЛЭЛЦЭЖ БАЙГАА АСУУДЛУУДТАЙ ХОЛБООТОЙ САНАЛ ХУРААЛТ ЯВАГДЛАА. САНАЛ ХУРААЛТЫН ХУГАЦАА 20 МИНУТ.**

**Тооллогын комиссын дарга Өмгөөллийн ЭмДиЭс энд Хаанлекс ХХН-ийн партнер С.Батбуян тооллогын дүнг уншиж танилцуулав.**

“ЛэндМН ББСБ” ХК-ийн ХЭЭХ-ын Тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгэж дууслаа. Тооллогын комиссын бүрэлдэхүүнд миний бие С.Батбуян, гишүүд П.Урангоо, Ж.Булган, Х.Одончимэг гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажиллалаа. Хэлэлцсэн асуудал тус бүрээр санал хураалтын дүнг танилцуулбал:

### **САНАЛ ХУРААЛТЫН ДҮН:**

**1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай санал хураалтын дүн:**

**Зөвшөөрсөн: 623,043,635 (100.00%)**

**Татгалзсан: 0 (0%)**

**Түтгэлзсэн: 15,929 (0.00%)**

**2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнийг сонгох санал хураалтын дүн:**

ТУЗ-ийн ердийн гишүүн Очирсүрэнгийн Болдбаатар

**Зөвшөөрсөн: 623,247,799 (11.12%)**

ТУЗ-ийн ердийн гишүүн Володъяагийн Баярсайхан

**Зөвшөөрсөн: 623,796,813 (11.13%)**

ТУЗ-ийн ердийн гишүүн Сэнгээгийн Энх-Амгалан

**Зөвшөөрсөн: 622,793,584 (11.11%)**

ТУЗ-ийн ердийн гишүүнээр Баатархүүгийн Хос-Эрдэнэ

**Зөвшөөрсөн: 623,084,985 (11.11%)**

ТУЗ-ийн ердийн гишүүнээр Болдын Итгэл

**Зөвшөөрсөн: 622,603,814 (11.10%)**

ТУЗ-ийн ердийн гишүүнээр Цэрэндоржийн Ууганбаяр

**Зөвшөөрсөн: 623,350,932 (11.12%)**

**3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгох санал хураалтын дүн:**

ТУЗ-ийн хараат бус гишүүн Сүрэнхүүгийн Боргил

**Зөвшөөрсөн: 622,681,458 (11.11%)**

ТУЗ-ийн хараат бус гишүүн Жигдэнгийн Жаргалсүрэн

**Зөвшөөрсөн: 622,619,441 (11.10%)**

ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Даваасамбуугийн Галхүү

**Зөвшөөрсөн: 622,790,185 (11.11%)**

**4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны төсвийг батлах санал хураалтын дүн:**

**Зөвшөөрсөн: 622,957,479 (100.00%)**

**Татгалзсан: 0 (0%)**

**Түтгэлзсэн: 0 (0%)**

Хэлэлцэх асуудал тус бүрээр санал хураалтын нэгтгэл, Компанийн тухай хуулийн 77.4 дэх хэсэг, СЗХ-ны санал хураах холбогдох журамд нийцсэн байдлаар гарсан тул санал хураалтын дүн хүчинтэй болно.

Хэлэлцэх асуудалтай холбоотой хүчингүй болсон саналын хуудас байхгүй. Хэлэлцсэн асуудал тус бүрээр танилцуулбал Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах санал хураалтад хүчингүй болсон саналын хуудас 0; ТУЗ-ийн ердийн гишүүн сонгох санал хураалтад хүчингүй болсон саналын хуудас 0; ТУЗ-ийн хараат бус гишүүн сонгох санал хураалтад хүчингүй болсон саналын хуудас 0; ТУЗ-ийн 2022 оны төсвийг батлах санал хураалтад мөн хүчингүй болсон саналын хуудас 0 болно.

Өмнө танилцуулсан санал хураалтын дүнд түтгэлзсэн саналын тоо байгааг танилцуулсан ба санал хураалтын системд арван мянганы орноор нарийвчилсан учир санал хураалтын дүнгийн нэгтгэл нь арван мянганы орноор нарийвчилсан хувиар гарч байгааг дахин дурдаж байна.

Ийнхүү тооллогын комиссын тогтоолыг гаргаж 2022.03.26-ны өдрийн “ЛэндММН ББСБ” ХК-ийн ХЭЭХ-ын санал хураалтын дүнг баталгаажуулж байна. Та бүхэнд баярлалаа.

**ХЭЭХ-ын дарга Б.Удвал ХЭЭХ-аас гарсан шийдвэрүүдийг уншиж танилцуулав /ХЭЭХ-аас гарсан шийдвэрийг хавсаргав/.**

**ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:**

  
Ж.МӨНХЦЭЦЭГ  
Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга

**ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:**

  
 Б.УДВАЛ  
ЛэндМН ББСБ ХК-ийн Гүйцэтгэх захирал, ХЭЭХ-ын дарга  
 М.ТҮВШИНЖАРГАЛ  
ЛэндМН ББСБ ХК-ийн Санхүү, үйл ажиллагаа хариуцсан захирал,  
ХЭЭХ-ыг зохион байгуулах комиссын дарга